



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 07 сарын 30 өдөр

Дугаар А/103

Улаанбаатар хот

Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.4, 63.1.5 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, мөн зүйлийн 14.4 дэх хэсэг, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.6 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.7 дахь хэсэг, 48 дугаар зүйлийн 48.3 дахь хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 24/33 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 2025 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хавсралтаар баталж, уг төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны эрхийг “Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар” ОНӨААТҮГ(Б.Мөнхбат)-т шилжүүлэн, худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журамд нийцүүлэн зохион байгуулж, үр дүнг танилцуулж, захиалагчийн хяналт тавьж ажиллахыг даалгасугай.

2.Захирамжийн хавсралтад заасан төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхэд шаардлагатай хөрөнгийг гүйцэтгэлээр нь холбогдох хууль, журмын дагуу хянан баталгаажуулж, санхүүжилтийн эрх нээхийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын Хөрөнгө оруулалтын хэлтэс (Б.Гантулга)-т, нээсэн эрхийг үндэслэн батлагдсан төсвийн сар, улирлын хуваарийн дагуу санхүүжүүлэхийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Л.Эрдэнэбадрах)-т, хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон хөрөнгийг зохих журмын дагуу бүртгэлжүүлж, хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Өмчийн харилцааны газар (В.Оюумаа)-т тус тус даалгасугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар ханган ажиллахыг Нийслэлийн Засаг даргын эдийн засгийн хөгжил, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч Т.Даваадалайд даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ



Х.НЯМБААТАР

1725020510

Нийслэлийн Засаг даргын 2025 оны
 07 дүгээр сарын 30 ны өдрийн
 А/103 дугаар захирамжийн
 хавсралт

НИЙСЛЭЛИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ
 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

(сая төгрөг)

Д/д	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		Төсөвт өртөг	2025 онд санхүүжих дүн
		Эхлэх	Дуусах		
1	Эрүүл мэндийн төвийн цогцолбор /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 24 дүгээр хороо/ ажлын дуусгал	2022	2026	3,208.9	1,000.0
2	Хороо, өрхийн эмнэлэг, цагдаагийн хэсгийн цогцолбор барилга (Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 18 дугаар хороо)-ын ажлын дуусгал	2024	2025	684.9	684.9
3	Бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор /Сонгинохайрхан дүүрэг, 8 дугаар хороо/ дуусгал	2022	2025	2,385.4	2,385.4
4	Бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор /Сонгинохайрхан дүүрэг, 26 дугаар хороо/	2022	2026	6,168.7	3,083.7
5	Бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор (Хан-Уул дүүрэг, 24 дүгээр хороо) дуусгал	2024	2025	1,964.5	1,964.5
6	Сургуулийн барилга, 640 суудал /Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 30 дугаар хороо/ ажлын дуусгал	2022	2025	4,808.7	4,208.7
7	Сургуулийн барилга, 640 суудал (Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 14 дүгээр хороо) ажлын дуусгал	2022	2025	3,090.7	3,090.7
8	Нийтийн зориулалттай орон сууцны гадна фасад засвар (БНД, 39, 42 дугаар байр, 3 дугаар хороо) ажлын дуусгал	2024	2025	228.7	228.7
9	Багц-3 Нийтийн зориулалттай орон сууцны дээвэр, фасадны засварын ажил (Улаанбаатар хот) (61 дүгээр байрны фасад засвар Баянгол дүүрэг, 19 дүгээр хороо)-ын дуусгал	2024	2025	180.6	180.6
10	Багц-3: Боловсролын салбарын барилгын их засвар (Улаанбаатар хот) (Баянгол дүүрэг, 89 дүгээр цэцэрлэг) ажлын дуусгал	2024	2025	749.4	749.4
11	Зайсан орчмын хотхонуудын усан хангамжийн төвлөрсөн систем /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/ нэмэлт тохижилтын ажил	2024	2025	4,720.5	2,720.5
ДҮН				28,191.0	20,297.1

